

Тогтвортой хөгжлийн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд их, дээд сургуулиудын гүйцэтгэх үүрэг

Б.Бурмаа*

Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Физикийн Тэнхим

Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд их, дээд сургуулиудын гүйцэтгэх, үүрэг хариуцлагын талаар НҮБ, ЮНЕСКО-ийн албан ёсны бичиг баримтуудад тусгагдаж буй үзэл санаанууд, түүнийг хэрэгжүүлэх үйл явцын талаар хийж буй харьцуулсан судалгааны үр дүнгээс тодорхой асуудлаар товч тойм бэлтгэн агуулгыг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн түүхэн замналаас.
- Дээд боловсролын салбар дахь тогтвортой хөгжлийн боловсролын үйл явцаас (2000-2015).
- Тогтвортой хөгжил ба тогтвортой хөгжлийн боловсролын зорилго (2015-2030).

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛААС

Тогтвортой хөгжил (ТХ) ба Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын талаар дэлхийн түвшинд олон тооны арга хэмжээнүүд зохиогдож, төрөл бүрийн төсөл хөтөлбөрүүд боловсрогдон хэрэгжих явцад “Тогтвортой байдал” (Sustainable), Тогтвортой хөгжил (Sustainable Development) гэсэн ухагдахуунууд өргөн хэрэглэгдэх болсон билээ. Тогтвортой байдал бол динамик төлөв байдал бөгөөд тасралтгүй боловсронгуй болж байх зорилгыг илэрхийлнэ. Тогтвортой байдалд хүрээд зогсох биш байнга өөрчлөгдөх процесс процесс бөгөөд түүнд хүрэх арга зам болох тогтвортой хөгжлийг байнга шинээр хэлэлцэн тохирч байх ёстой гэсэн санааг энэ чиглэлээр хийгдэж буй судалгаанд чухалчлан авч үздэг. Энэхүү динамик төлөв байдал, байнга шинээр хэлэлцэн тохирч байх ёстой, сайн сайхан ирээдүйг зөгнөсөн үйл явцын хөгжлийн түүхэн замналыг та бүхэнд ахин нэг сануулах үүднээс хүн бүхний мэдэх тодорхой хэдэн арга хэмжээг товч дурьдах нь зүйтэй болов уу гэж үзлээ.

1972 онд НҮБ-ын “Хүрээлэн буй орчин” сэдэвт хуралдаан болж анх удаа **экологн ба хөгжил** гэсэн ойлголтуудыг уяалдаа холбоонд нь авч үзсэнтэй холбогдон экологийн боловсрол, хүрээлэн буй орчны боловсрол (environmental education)-ын тухай ойлголтууд хөндөгдөж эхэлсэн.

1992 онд “Хүрээлэн буй орчин ба хөгжил” сэдэвт эх дэлхийн дээд хэмжээний уулзалтаас “Хөгжлийн хөтөлбөр 21”-баримт бичгийг

батлан, эко системийн доройтол, хүн амын болон үйлдвэрлэлийн өсөлт, байгалийн нөөц чадавхийн хязгаарлагдмал байдал, хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын хэрэглээний түвшний ялгаа зэрэг нь хүн төрөлхтний хөгжилд зөрчил үүсгэж манай дэлхийн байгал, нийгмийн систем бүхэлдээ тогтворжиж чадахгүй байгааг онцлон тэмдэглэсэн. Иймд барууны орнуудын хөгжлийн загварыг цаашид хүн төрөлхтний хэтийн хөгжилд бүхэлд нь хэрэглэх боломжгүй гэж дүгнээд хөгжлийн шинэ загвар болох **“Тогтвортой хөгжил”-ийн загварыг** дэвшүүлж, ТХ-ийн гурван багана нь эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгэм байна гэж тодорхойлсон. Байгаль орчинд ээлтэй хөгжлийн талаар “Our Common Future” нэртэй Брундтландын тайланд **тогтвортой хөгжил-ухагдахууныг** “өнөө үеийнхэн өөрсдийн хэрэгцээгээ хангахдаа ирээдүйн үеийнхэн маань өөрсдийн хэрэгцээгээ хангаж чадахгүй байх эрсдлийг буй болгохгүй байх хөгжил” (Sustainable development is development that meets the needs of the present without compromising the ability of future generations to meet their own needs) гэж тодорхойлсон. Энэ хуралдаанд манай улсын тухайн үеийн ерөнхий сайд Д.Бямбасүрэн оролцож, манай боловсролын салбарт экологийн боловсролыг эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эхэлсэн. Одоо ч үргэлжилсээр байна.

2002 онд НҮБ-ын Даяан дэлхийн тогтвортой хөгжлийн Их чуулганаас “Тогтвортой хөгжлийн боловсрол нь бидний ирээдүйдээ оруулж буй хөрөнгө оруулалт” гэсэн санааг дэвшүүлж “... тогтвортой хөгжилд хамрах зарчим, мэдлэг

* Electronic address: burmaa.banzragch@yahoo.de

чадвар, үзэл хандлага, үнэт зүйлсийг эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны цогц бүрдлийн интеграцид бодитойгоор тусгах замаар бүр анхан шатнаас эхлэн их, дээд сургууль хүртэлх боловсрол эзэмшүүлэх сургалтын бүх хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай болохыг тунхагласан. 2004 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр “Тогтвортой хөгжлийн боловсролын 10 жил (2005-2014)” хөтөлбөрийг батлан, дэлхийн бүх орнуудын засгийн газар, парламентийн түвшинд шийдвэрүүд гарч боловсролын салбарт төрөл бүрийн хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСОЛЫН ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦААС

Их, дээд сургуулиуд тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх явцад ямар үүрэг, хариуцлага хүлээж байгааг авч үзэхийн өмнө дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэдэг эдгээр сургуулиуд нийгмийн өмнө ямар тодорхой үүргийг хүлээдэг талаар товч дурдах нь зүйтэй юм. . Дээд боловсролын бодлогын баримт бичгүүдэд дараах асуудлуудыг голчлон тусгадаг. Үүнд:

- **Сургалтын байгууллага** болохын хувьд нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх мэргэжилтнүүд болон удирдах боловсон хүчнийг бэлтгэдэг **хичээл сургалтын ажлыг** явуулдаг.
- **Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага** болохын хувьд дэлхийн болон нийгмийн бүхийл салбар дахь түлхүүр асуудлуудыг хамарсан судалгаануудыг хэрэгжүүлдэг.
- Боловсролын салбарын гол мэргэжилтэн болох **ирээдүйн сурган хүмүүжүүлэгчдийг** бэлтгэдэг.

Энэхүү өргөн хүрээтэй үйл ажиллагаанаас энэ удаа 2002 онд болсон НҮБ-ын Даяан дэлхийн тогтвортой хөгжлийн Их чуулган, шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор **чанартай боловсрол** эзэмшүүлэх зорилгоор **сургалтын хөтөлбөрийн реформыг** хийх үйл явц ТХБ-ын 10 жилийн хугацаанд хэрэгжиж ирлээ.

Сургалтын хөтөлбөрийн реформ нь муу хөтөлбөрийг сайнаар солих асуудал биш харин хүн төрөлхтний тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж чадахуйцаар дээд боловсролын чанарыг

дээшлүүлэхтэй холбоотой асуудал юм. Сургалтын хөтөлбөрийн реформ нь улс бүрийн хөгжлийн түвшин, боловсролын салбарт хуримтлуулсан туршлагатай уялдан өөр өөрийн онцлогтойгоор хэрэгжиж байна. Европ тивд үүсэж, хөгжсөн боловсролын классик онолын хүрээнд боловсруулан хэрэгжүүлж ирсэн герман, орос, монгол хэл дээр “Lehrplan”, “Учебный план”, “Сургалтын хөтөлбөр” гэж нэрлэгддэг сургалтын хөтөлбөрүүд нь тодорхой шинжлэх ухааны агуулгыг түлхүү тусгасан ямар, бүлэг, сэдвийг заахыг нарийвчлан заадаг ижил төрлийн хөтөлбөрүүд юм. Ийм төрлийн хөтөлбөрийг **сургалтын оролтод төвлөрсөн хөтөлбөр** гэж нэрлэдэг. Үүний оронд энэхүү агуулгыг судалсны дараа оюутнууд юу мэддэг, чаддаг болсон байх вэ гэдгийг тусгасан, сургалтын амжилтын хүлээгдэж буй үр дүнд баримжаалсан **сургалтын гаралтад төвлөрсөн** (learning outcomes), хоёр шатлалтай (bachelor und master) хөтөлбөр боловсруулах шаардлага тулгарсан. Манай орны хувьд уламжлалт хөтөлбөрийн хэв маяг, түүнийг шинэчлэж эхэлсэн цаг хугацаа нь европын орнуудтай ойролцоо байсан учир хөтөлбөрийн реформ хийх гарааны төлөв байдал нь ижил байсан гэж үзэж болно. МУИС-ийн мэргэжлийн дидактикийн сургалт судалгааны судлаачид Европын орнуудад хийгдсэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг түлхүү судлаж, ерөнхий үзэл санааг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн юм. Европын холбоо нь их, дээд сургуулийн стандарт ба сургалтын чанарыг дээшлүүлэх ерөнхий чиг шугамаа гаргахдаа өргөн хүрээтэй судалгаа, боловсролын шинжлэх ухааны орчин цагийн үзэл баримтлал дээр суурилан, дараах үе шаттай боловсруулсан. Эхний ээлжинд Европ тивийн хуьд “Standards and guidelines for quality assurance in the European Higher Education Area” бичиг баримтыг гаргаад дараа нь холбооны улс бүр энэ хүрээнд өөрийн онцлогоо тооцон боловсруулсан ижил төрлийн бичиг баримтыг гаргаад, улмаар энэ хүрээнд их, дээд сургууль бүр өөрийн онцлогтой сургалтын хөтөлбөрөө боловсруулсан. Жишээ нь Герман улсын хувьд төр засаг, парламентийн хүрээнд шийдвэрүүд гарч, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн яамд, их, дээд сургуулийн холбоод олон төрлийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжээд,

сургуулиуд дээр хөтөлбөр боловсруулах ажлыг сургалтын хөтөлбөр гэж юу болохыг мэддэг, мөн хийдэг мэргэжилтнүүд хоёр шатлалтайгаар гүйцэтгэсэн. Үүнд:

- Тухайн сургуулийн боловсрол судлалын эрдэмтэн судлаачид хөтөлбөр боловсруулах ерөнхий загварыг өөрийн сургуулийн онцлогийг тооцон боловсруулах,
- Мэргэжил тус бүрийн эрдэмтэн, багш нар энэхүү загварын учир утга, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу өөрсдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах байдлаар хэрэгжсэн.

Нийгэм тасралт үгүй өөрчлөгдөж, дээд боловсролтой мэргэжилтний мэдлэг, чадварт тавигдаж шаардлага ч мөн өөрчлөгдөж байгаатай уялдан сургалтын хөтөлбөрийн шинэчлэл ч тасралт үгүй явагдаж байна.

Иймд физикийн салбарын залуу багш нар өөрийн заадаг хичээлийн хөтөлбөрөө орчин цагийн чиг хандлагын дагуу боловсруулахад санаа авч болох зарим асуудлыг хөндлөө. Орчин үед нэр нь өөр байж болох ч бүтцийн хувьд сургалтын хөтөлбөрийг сургалтын зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ гэх мэт элемент бүхий загварын дагуу боловсруулж байна. Тодорхой хичээлийн **модул хөтөлбөрт** эдгээр элементүүдийн утга санааг товч утгаар тусгадаг.

Сургалтын зорилго: Зорилгыг оюутнууд ямар мэдлэг чадвар эзэмшсэн байх вэ гэдгээр тодорхойлох болсонтой уялдан мэдлэг, чадвар компетенц гэсэн ухагдахууныг хэрэглэдэг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) 2000 оноос хүн бүр тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахын тулд ямар мэдлэг, чадвар, хандлагатай байхыг нарийвчлах үүднээс “Definition and selection of competencies (DeSeCo): Theoretical and conceptual foundations. 2002.” судалгааны төсөл хэрэгжүүлж шинжлэх ухаан, улс төрийн бодлого, бодит амьдрал хоорондын холбоон дээр хамгийн чухал компетенцуудыг тодорхойлох онолын үндэслэл болон үзэл баримтлалыг боловсруулах зорилго тавьсан. Герман улсын эрдэмтэн Вайнерт (Weinert)-ийн компетенц ухагдахууны тодорхойлолтыг түүний төсөлд оруулсан чухал хувь нэмэр гэж үнэлсэн байдаг. Энэхүү тодорхойлолтод “Компетенц нь хувь хүнд байж болох буюу сурч болох, тодорхой асуудлыг шийдвэрлэх **когнитив чадвар ба дадал**, үүнтэй холбоотой **хүсэл**

тэмүүлэл, сэтгэл хөөрөл, бэлэн байдал ба энэхүү чадвараа ямар ч нөхцөлд амжилттай, хариуцлагатай ашиглаж чадах **социал чадвар**” гэсэн санааг илэрхийлдэг. (Б.Бурмаа, Албан бус орчуулга) Европын холбооны орнууд аль ч түвшний боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа компетенц ухагдахууныг дээрх тодорхойлолтын утга санааны дагуу авч үзж байна. Уг нь компетенц ухагдахууны утгыг энэ тодорхойлолтын дагуу хэрэглэх юм бол мэдлэг, чадвар зэрэг үгийг давхар хэрэглэх алба байхгүй. Чадвар гэдгийн дор мэдлэгээ хэрэглээд асуудал шийдвэрлэж чадаж байгааг ойлгодог тул энэ ухагдахуун дотор цээжилсэн биш хэрэглэгдэг мэдлэг агуулгадаж байга юм. Боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөрийг боловсруулах үед онолын түвшинд боловсруулсан компетенцийн загваруудаас сонголт хийх болсон. Орчин үед норматив-бүтцийн загвар (normative structure - competence model)-ыг боловсролын стандарт, хөтөлбөрийг боловсруулахад түлхүү хэрэглэж байна. Энэхүү загвар нь дараах бүтцийн элементүүдтэй:

- Компетенцийн мужууд (Areas of competence)
- Компетенц эзэмшүүлэх агуулга (The content domain)
- Компетенцийн хөгжлийн түвшин (Levels of competence)

Тухайн үед ЮНЕСКО өөрийн гишүүн орнуудад компетенцийн мужуудыг сонгох чиглээлээр суралцахуй ₮ багана нэртэй дараах загварыг санал болгосон бөгөөд азийн орнууд түлхүү хэрэглэдэг.

- Мэдэхийг сурах (Learning to know)
- Бүтээхийг сурах (Learning to do)
- Оршин байхыг сурах (Learning to be)
- Хамтдаа нийгэмшин амьдрахыг сурах (Learning to socially live together)

Манай зарим арим судлаачид эдгээр англи үгийг мэдэхийн тулд, бүтээхийн тулд гэх зэргээр монгол хэлэнд орчуулдаг. 2000-2014 онд хэрэгжсэн “Бүх нитийн боловсрол” – хөтөлбөрийн утга санааны дагуу бол сурах гэж орчуулах нь зүйтэй. Учир нь сур гэхээр шууд сурчихдаг юм биш хүн эхлээд “сурахыг сурах” учиртай. Европын орнуудын хувьд утга санааны хувь ерөнхийдөө дөстэй 4 элемент бүхий загварыг хэрэглэдэг.

Германы их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт дараах элементүүд бүхий загварыг түлхүү хэрэглэсэн байдаг. Үүнд:

- Мэргэжлийн компетенц (Fachkompetenz)
- Аргын компетенц (Methodenkompetenz,)
- Хувийн компетенц (Personalkompetenz)
- Социал компетенц (Sozialkompetenz)

Эдгээр муж бүрийн дор юуг ойлгох талаар сургууль бүр өөрийн онцлогтойгоор боловсруулж багш нарт баримжаа болгон өгдөг.

Сургалтын агуулга. Компетец ухагдахуун болон түүнийг эзэмшүүлэх мужуудын утга санаанаас хамаараад зөвхөн когнитив чадвараас гадна, аффектив болон социал чадваруудыг тооцох учир физикийн агуулгаас гадна амьдрах болон ажил эрхлэх үйлд физикийн мэдлэгээ хаана хэрхэн ашиглахтай холбоотой агуулгыг сонгон физикийн агуулгад интегралцлах шаардлага гарна. Жишээ нь физикийн мэдлэг, чадвараа ашиглан ТХ-ийн асуудлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй зөв шийдвэр гаргах үйлд оролцох гэх мэт.

Сургалтын арга. Сургалтын зорилго, агуулга өөрчлөгдсөнөөс сургалтын аргад маш их өөрчлөлт хийх шаардлага тулгардаг. Сургалтын агуулга шинжлэх ухааны агуулгад төвлөрч байх үед хичээл дээр суралцагчдад аль болох их бага хугацаанд эзэмшүүлэх шаардлага байсан учир агуулгыг “заах арга” илүү хөгжсөн. Энэ аргын сэтгэл судлалын онолд хүнийг юу ч бичиж болдог цагаан цаас мэтээр төсөөлж, багшийн мэдлэг тэр чигээрээ оюутны толгойд дамжиж болдог гэсэн санаа давамгайлсан байдаг. Гэтэл орчин цагийн суралцахуйн сэтгэл судлал, тархи судлал дээр суурилсан конструктив онол нь хүн гадаад мэдээллийг зөвхөн өөрт байгаа хур мэдлэгийн суурин дээр хүлээн авч өөрийн онцлогтойгоор боловсруулдаг, багшийн мэдлэг шууд дамжихгүй болохыг онол болон практик түвшинд батлах болсон. Энэ нь багшийн лекцийг сонсож суугаа 100 оюутан багшийн тайлбарыг 100 янзаар л ойлгож суугаа гэсэн үг юм. Үүнтэй уялдан дээд боловсролын салбарын бодлого, стандарт, хөтөлбөрт оюутан төвтэй суралцахуй ба багшлахуй ба үнэлгээ (Student-centered learning, teaching and assessment) гэсэн ухагдахууныг хэрэглэж энд юу чухал болохыг “Student-centered learning, teaching plays an impotent role in stimulating students’ motivation, self-reflection and engagement in the learning process” гэж илэрхийлдэг. Энд байгаа ухагдахуунуудын утгыг зөвхөн толь бичиг

ашиглан ойлгох боломж тун хомс тул их сургуулийн багш хүн ямар ч хичээл заахдаа хүн яаж сурдаг, сурч буй хүний сургах орчинг бүрдүүлэх талаар суралцахуйн сэтгэл судла, сурган, дидактикийн зохи мэдлэг, баримжаатай байх шаардлага гарч ирнэ.

Сургалтын үнэлгээ. Сургалтын зорилгыг сургалтын амжилтын хүлээгдэж буй үр дүнгээр үнэлэх болж байгаа нь сургалтын чанарыг баталгаатай болгож байгаа гол зүйл юм. Гэвч оюутны эзэмших ёстой когнитив, аффектив, социал чадваруудыг үнэлэхийн тулд зорилгоо үнэлэх боломжтойгоор томъёолохоос эхлээд, эдгээрийг хэрхэн яаж үнэлэх аргын талаар мөн л их зүйлийг мэдэх шаардлага багшд гарч ирнэ.

Сургалтын хөтөлбөрийн реформтой зэрэгцэн тавигдсан чухал асуудал нь **их, дээд сургуулийн багш нарын дидактик ур чадварыг дээшлүүлэх** асуудал юм. Жишээ нь Герман улсын хувьд бүх их дээд сургуулиуд дээр сургалтанд оролцдог эрэмтэн багш нарын дидактик ур чадварыг дээшлүүлэх сургалт явуулж, сертификат олгодог төвүүд байгуулагдсан бөгөөд одоо энэ төвүүд нь “компетенцийн төв” нэртэй болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Мөн “Профессор” гэж хэн бэ гэдэг талаар асуудал дэвшүүлж, энэ цол хэргэмийг тодорхой шинжлэх ухааны салбарт хийсэн судалгааны бүтээлээр олгож ирсэнд шүүмжлэлтэй хандаж, хичээл, сургалтын ажлыг гардан гүйцэтгэж, түүнд амжилт гаргаж буй багш хүнд олгох ёстой гэж үзэх хандлага нилээд давамгайлах болсон. Оюутан төвтэй суралцахуй ба багшлахуйн үзэл санааг бодит амьдрал дээр хэрэгжүүлж, оюутнуудын сонихол хэрэгцээг тооцон, тэдний сурах, бүтээх хүсэл эрмэлзлэлийг өдөөсөн төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар сургалтын амжилтыг ахиулж байгаа багш нарыг дэмжих сан байгуулагдсан. “Германы их, дээд сургуулийн захиралуудын бага хурал” нэртэй байгууллага сүүлийн жилүүдэд энэ сангаас зарласан шалгаруулалтад тэргүүн байр эзэлсэн багш нарт шагнал олгох үйл ажиллагааг жил бүр явуулж, тэдний хичээл сургалтын арга зүйн инновацийг сурталчлаж байна. Бүхэлд нь авч үзвэл **хичээл сургалтын ажлыг судалгаатай ижил түвшинд тавина** гэдгийг чухалчлаж байна. Гэтэл манайд “сургалтын их сургуулиас судалгааны их сургуульд шилжинэ” гээд байгаа нь сургалтаа болоод байгаа гэж индүүрээд байгаа юм биш биздээ. Их, дээд сургуулийн

сургалтын чанар тун тааруу байгааг нийгэм бүхэлдээ хүлээн зөвшөөрч, шүүмжлэж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ЗОРИЛГО (2015-2030)

2013-2015 онуудад НҮБ, ЮНЕСКО –аас ТХ, ТХБ-ын чиглэлээр сүүлийн 10-15 жилийн турш хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр дүнд үнэлгээ (мониторинг) хийгээд улмаар ТХ ба ТХБ-ын 2030 он хүртлэх зорилгуудыг дэвшүүлсэн хөтөлбөрүүд батлагдан гарсан. Үүнд :

- ТХБ-ын 10 жил (2005-2014) –ийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх “Даяар Үйлийн Хөтөлбөр” (Global Action Programm)-ыг баталсан.
- 2000 онд болсон дэлхийн боловсролын форумас баталсан, Бүх нийтийн боловсрол (Education for All)- хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх “ Боловсролын шинэ үзэл баримтлал” (New vision for education)-хөтөлбөрийг баталсан.
- 2015 оны 9-р сард НҮБ-ын ерөнхий чуулган болж 2000 оноос хэрэгжсэн “Мянганы хөгжлийн зорилт”-ын үр дүнг дүгнээд цаашид 2015 он хүртэл хэрэгжсэн олон нэртэй хөтөлбөрүүдийн оронд 2030 он хүртэл хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн зорилгууд” (Sustainable Development Goals)-ыг баталсан.

Тогтвортой хөгжлийн хувьд 2030 он хүртэл хэрэгжих 17 зорилгыг тодорхойлсон.

- 4-р зорилго нь ТХБ-ын зорилго. Ийнхүү тогтвортой хөгжлийн зорилго анх удаа тодорхойлогдсон бөгөөд түүнд дээр дурьдсан “боловсролын шинэ үзэл баримтлал”-ын утга санаа тусгагсан.
- ТХ-ийн 17 зорилго биелэгдэх үндэс нь тогтвортой хөгжлийн боловсрол болно гэж үзсэн байна. .

ТХБ-ын зорилгыг “**2030 он хүртэл бүх хүнд бүх нийтийг хамарсан, үл алагчилсан, дээд зэргийн чанартай боловсрол олгох ба бүх нийтийн насан туршдаа суралцах боломжыг баталгаатай болгоно**” гэж томъёолсон.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө дээр дурьдсан 2015-2019 онд хэрэгжих “Даяар үйлийн хөтөлбөр”-ийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа одоо дэлхийн бүх оронд өрнөж байна.

Даяар үйлийн хөтөлбөрийн хувьд:

- Ерөнхий зорилго: ТХ –ийг хурдасгахад дэвшил гаргах чиглэлээр **боловсрол ба суралцахуйн** бүхийл салбар, **бүх түвшинд** үйл ажиллагааг эрчимжүүлэх (The overarching goal of the GAP is “to generate and scale up action in all levels and areas of education and learning to accelerate progress towards sustainable development”)
- Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд:
 - Хүн бүрт ТХ-д хувь нэмэр оруулах боломжыг буй болгох, тийм мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийн үнэлэмж эзэмшихүйцээр **боловсрол ба суралцахуйг** шинэ чиглэлд хандуулах (“to reorient education and learning so that everyone has the opportunity to acquire the knowledge, skills, values and attitudes that empower them to contribute to sustainable development”)
 - ТХ-ийг дэмжиж байгаа бүхий л хөтөлбөр, үйл ажиллагаанд **боловсрол ба суралцахуйг** хамтад нь авч үзэх (“to strengthen education and learning in all agendas, programmes and activities that promote sustainable development”)
- Эдгээр зорилго зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон бөгөөд утга санааг нь их сургуулийн түвшинд буулгавал:
 - Их сургуулийн хөгжлийн бодлогод тогтвортой хөгжлийн боловсролыг интегралчлах
 - Хичээл сургалт, судалгаа эрдэм шинжилгээ төдийгүй байгууллагын барилга байгууламж, менежмент зэрэг бүхийл үйл ажиллагаа нь ТХ-ийг дэмжсэн байх.
 - ТХБ-ийг эзэмшүүлэгч, “*Change Agents*” болох багш нарын мэдлэг чадварыг улам нэмэгдүүлэх
 - Залуу үеийг өөрчлөлт хувирлын хэрэгжүүлэгч эзэд байхаар энэ үйл хэрэгт тэдний оролцоог хүчтэй болгох, хурдасгах,
 - Орон нутгийн тогтвортой хөгжилд тулгамдаад байгаа тодорхой асуудлын өвөрмөц хэрэгцээг шийдвэрлэхэд чиглэсэн ТХБ-ын үйл ажиллагааг дэмжих

Багш нарын хувьд:

- Хичээлийн хөтөлбөртөө уур амьсгалын өөрчлөлт зэрэг ТХ-ийн асуудлуудыг интегралчлах,
- Сурах ба багшлах үйл ажиллагааг оюутан төвтэй, интерактив аргаар хэрэгжүүлэх,
- Сургалтын үр дүн нь шүүмжлэлт сэтгэлгээ, системийн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар зэрэг цөм компетенцийг (**core competencies**) эзэмшүүлэх

Орчин үед дээд боловсролын салбарт “Sustainable University” болох хөдөлгөөн өрнөж, хичээл сургалт, эрдэм шинжилгээ судалгаа, оюутанд үзүүлэх үйлчилгээ, сургалтын орчин бүрдүүлэх үйл ажиллагаа нь ТХ ба ТХБ-ын талаар 2030 он хүртэл дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Qualitaetsentwicklung an Hochschulen: (Чанарын хөгжлийн 10 жилд хуримтлуулсан туршлага ба сургамж), Beitrage zur Hochschulpolitik 8/2006, Bonn.
- [2] Neue Anforderungen an die Lehre in Bachelor und Master- Studiengängen. (Бакалавр-Магистрын сургалтанд тавигдаж буй шинэ шаардлагууд) Bologna Zentrum. Beitrage zur Hochschulpolitik 1/2009, Bonn
- [3] Studienreform nach Leuven. (Үр дүн ба 2010 оны дараах ирээдүйн төсөөлөл) Beitrage zur Hochschulpolitik 3/2010, Bonn.
- [4] Standards and guidelines for quality assurance in the European Higher Education Area. Beitrage zur Hochschulpolitik 3/2010, Bonn. Beitrage zur Hochschulpolitik 3/2015, Bonn.
- [5] Rychen, Dominique Simone/ Salganik, Laure Hersh (2001): Defining and selecting key competencies. Goettingen, Germany: Hogrefe&Huber.
- [6] Судалгааны тайлан: Сургууль соёлын хөгжлийн шинэ чиг хандлага(киррикулим хөгжлийн онол арга зүй) Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага (стандарт, киррикулимийн онол арга зүй) БСШУЯ-ны захиалгат төсөл, Төслийн удирдагч Б.Бурмаа, УБ, 2002-2003 он.
- [7] B.Burmaa, Qualitaetssicherung in Hochschulen der Mongolei. Beitrage zur Hochschulpolitik, 7/1999, p.37-41
- [8] П. Очирбат, Б.Бурмаа, Ц.Лувсандорж Устойчивое развитие и высшее образование. Международная конференция: “Образование и наука: Илтгэлийн эмхтгэл, х.128-131, УБ. 2005.
- [9] B.Burmaa, Ts. Luvsandorj. Towards restructuring high education curriculum in the light of paradigm changes in education. Международная конференция “Образование и наука” Илтгэлийн эмхтгэл, х.146-147, УБ. 2005
- [10] B.Burmaa, B. Menkhjargal und National ESD team: Integration of ESD concept into Mongolian primary and secondary education system. Зүүн азийн орнуудын уулзалт, БНХАУ Ханжоу, Илтгэлүүдийн эмхтгэл х. 56, 2007.
- [11] Б.Бурмаа ахлагчтай багийн гишүүд. “Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын 12 жилийн хөтөлбөрт тусгах нь”-багш нарт зориулсан зөвлөмж. Соёмбо принтинг, УБ, 2010
- [12] Ц.Даржаа, Б.Бурмаа. Дээд сургуулийн багш нарын дидактик ур чадварыг дээшлүүлэх сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулах. Судалгааны төслийн тайлбан. УБ, 2012.
- [13] Б.Бурмаа, Ц. Лхагважав. “Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн боловсролын талаар баримталж буй Дэлхий нийтийн бодлого” дэд хэсгийн судалгаа. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл. УБ, 2014-2015.
- [14] Б.Бурмаа ба багийн гишүүд. Албан бус боловсролын салбарт ТХБ-оор хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх (Сургагч багш нарыг бэлтгэх сургалтын материалыг боловсруулах, сургалт явуулах, цаашид ашиглах модуль хөтөлбөрийг боловсруулах) Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл. УБ, 2015-2016.
- [15] Б.Бурмаа, Д.Үүрийнтуяа, Ж.Дөлгөөн, Р. Дархижав. Тогтвортой хөгжлийн боловсролын даяар үйлийн хөтөлбөрийн зорилгыг (GAP) сургуулийн түвшинд хэрэгжүүлэх (СХД-ийн 65 –р сургуулийн багш нарыг оролцуулсан сургалт, туршилт судалгаа) УБ, 2016-2017.